



Төрийн албан хаагчдын жендэрийн тухай мэдлэг, ойлголтын одоогийн түвшин, түүнийг хэрхэн сайжруулах талаар



Р.Лхагвадорж

Дундговь аймгийн ЗДТГ, Нийгмийн
бодлогын хэлтсийн мэргэжилтэн

СЭДЭВ: “ЖЕНДЭРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТӨД ТУСГАХ НЬ” АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТ
Чойбалсан хот, Дорнод аймаг
2018 оны 12-р сарын 7-8-ны өдөр

Жендерийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт гэж юу вэ?



Хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөлд жендерийн үзэл баримтлалыг тусгах замаар хөгжлийн бодлогыг жендерийн агуулгатай болгох нь жендерийн мэдрэмжтэй бодлогын зарчим юм.



Дундговь аймгийн хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр 6, Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр 1, Боловсролын чиглэлээр 4, Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах 1, ХАА-н чиглэлийн 6, Байгаль орчны 1, Биеийн тамир, спортыг хөгжүүлэх 1, Засаг даргын мөрийн хөтөлбөр, Аймгийн нийгэм эдийн засгийн стратеги төлөвлөгөө гээд нийт 23 дэд хөтөлбөр, хөгжлийн бодлого хэрэгжиж байна




Дундговь аймгийн хэмжээнд батлагдан хэрэгжиж байгаа 23 дэд хөтөлбөр, бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийж, “Дундговь аймгийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө”, “Иргэний эрх зүйн боловсрол” аймгийн хөтөлбөр, “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр” гэсэн 3 баримт бичгийг “Жендерийн агуулга бүхий баримт бичиг”-ийн ангилалд орууллаа. Эдгээр баримт бичигт тусгагдсан жендерийн мэдрэмжтэй зорилтыг хангахад чиглэгдсэн үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжүүлж, хэрэгжилтийг хянаж, үр дүн, үр нөлөөг үнэлж ажиллах шаардлагатай юм.

“Жендерийн үр нөлөө бүхий баримтууд”-ын ангилалд нийт 16 дэд хөтөлбөр, бодлогын баримт бичгийг багтаан ангилсан бөгөөд эдгээр бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд жендерийн тэгш оролцоог хангаж ажиллах нь зүйтэй юм.

Хүйсээр ангилсан мэдээллийн судалгаа

Аймгийн ИТХ, ЗДТГ, 22 агентлаг, 15 сумын ЗДТГ-ын удирдлага, удирдах ажилтнуудын тоо, хүйсээр:

Аймгийн ИТХ, ЗДТГ




Аймгийн ИТХ, ЗДТГ-т нийт ажиллагсдын 20,4% нь дэд дарга, ахлах мэргэжилтэн бөгөөд тэдний 70% нь эрэгтэй, харин нийт мэргэжилтнүүдийн 71,4% нь эмэгтэй, хэлтэс агентлагийн нийт ажилтнуудын 41 нь дэд дарга, ахлах мэргэжилтэн бөгөөд 53,6%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна. Хэлтэс агентлагийн дэд дарга, ахлах мэргэжилтэн болон мэргэжилтнүүд, үйлчилгээний ажилтнуудын хувьд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харьцаа ойролцоо байна.


Агентлагууд, 22 байгууллага



15 сумын ЗДТГ-ын хувьд 78 нь дэд дарга, БЗД, ахлах мэргэжилтэн бөгөөд тэдний 63% нь эрэгтэй, мэргэжилтнүүдийн 64% нь эмэгтэй, үйлчилгээний ажилтнуудын 57% нь эмэгтэй байна.




Аймаг, сумын хэмжээнд шийдвэр гаргах түвшин дэх жендерийн байдал:



- Дундговь аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн 88,5%, Засаг даргын зөвлөлийн гишүүдийн 66,6%, хэлтэс, агентлагийн дарга нарын 82%, сумын ИТХ-ын дарга нарын 86,6%, сумын Засаг дарга нарын 80%, сумын Засаг даргын орлогчдын 73%, 79,7%, 15 сумын ИТХ-ын төлөөлөгчдийн 66%-ийг тус тус эрэгтэйчүүд эзэлж байна. Харин 15 сумын ЗДТГ-ын дарга нарын 80%-ийг л эмэгтэйчүүд эзэлж байна.
- Дээрх тоон үзүүлэлтээс харахад шийдвэр гаргах түвшинд эрэгтэйчүүдийн оролцоо давамгайл байна.





Жендерийн эрх
тэгш байдлын
талаарх ойлголт,
мэдлэг


Жендерийн эрх тэгш байдлын талаарх ойлголт, мэдлэг



Жендерийн асуудлаар тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтэн, ажилтнуудаас асуулгын судалгаа авч, судалгаанд аймгийн ЗДТГ, БСУСГ, ЭМГ, ХХҮХ, Цагдаагийн алба гээд 21 агентлаг, Нэгдсэн эмнэлэг, Сайнцагаан сумын ЗДТГ-ын ажилтнууд хамрагдлаа. .



- Ажил эрхлэлт, ажил эрхэлдэг салбараар нь авч үзвэл судалгаанд оролцогчдын 37% нь төрийн захиргаа, 25% нь төрийн үйлчилгээ, 7% нь төрийн өмчит үйлдвэрийн газар, 27% нь хувийн хэвшил, 4% нь ТББ-ын төлөөлөл байна.




■ Төрийн захиргаа ■ Төрийн үйлчилгээ ■ ТББ ■ Хувийн хэвшил ■ Төрийн өмчит

Жендерийн эрх тэгш байдлын талаарх ойлголт, мэдлэг



Ас: Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол улсын хууль байдгийг Та мэдэх үү?



Судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 71% нь Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол улсын хууль байдгийг “мэднэ” гэсэн бол 29% нь “мэдэхгүй” хэмээн хариулсан байна.

Ас: Жендерийн тэгш байдлыг Та юу гэж ойлгодог вэ?



Судалгаанд оролцогчдын хариулсан байдлаас харвал тэдний дийлэнх нь буюу 74% нь жендерийн тэгш байдлын талаар зөв ойлголттой байна.


Жендерийн эрх тэгш байдлын талаарх ойлголт, мэдлэг



Ас: Аймагт болон танай байгууллагад
жендерийн тэгш байдлыг хангахыг
дэмжсэн бодлогын зорилго, үйл
ажиллагааны төлөвлөгөө байдаг уу?

Ас: Уг бодлогын баримт бичгийг
хэрэгжүүлэхэд төлөвлөсөн төсөв
байдаг болов уу?


Судалгаанд оролцогчдын 47% нь аймагт болон тухайн байгууллагад
жендерийн тэгш байдлыг хангахыг дэмжсэн бодлогын зорилго үйл
ажиллагаа байдгийг “мэдэхгүй” хэмээн хариулсан бол 47% нь “байхгүй”,
6% нь “байдаг” гэсэн хариултыг өгчээ.



Харин уг бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд төлөвлөсөн төсөв
байдаг уу? гэсэн асуултанд дийлэнх нь буюу 63% нь “мэдэхгүй”, 34% нь
“байхгүй” гэсэн хариултыг өгсөн байна.

Жендерийн эрх тэгш байдлын талаарх ойлголт, мэдлэг

Ас: Та жендерийн агуулга бүхий ямар нэг сургалтанд хамрагдаж байсан уу?



Судалгаанд оролцогчдын 4% нь жендерийн агуулга бүхий ямар нэг сургалтанд “хэд хэдэн удаа хамрагдсан”, 24% нь “нэг л удаа хамрагдсан”, 72% нь “огт хамрагдаж байгаагүй” гэсэн хариултыг өгчээ.

Судалгаанд оролцогчдын тодорхойлсноор жендерийн хүрээнд дараах асуудлууд тулгамдаж байна. Үүнд:



- Жендерийн мэдрэмжтэй байдлыг удирдлагын түвшинд ойлгох
- Иргэдэд сургалт хийх, мэдээллийн төв байгуулах
- Статистик мэдээнд дүн шинжилгээ хийх
- Хандлагыг сайжруулах
- Тэгш оролцоог нэмэгдүүлэх
- Хөгжлийн үр шимийг ялгаварлалгүй тэгш хүртээх
- Тэгш төлөөлөлтэй шийдвэр гаргах
- Спортын үйл ажиллагаанд тэгш оролцуулах
- Ач холбогдлыг ойлгуулж, эцсийн үр дүнг тодорхойлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх
- Салбарын бодлого төлөвлөлтөнд дүн шинжилгээ хийх
- Жендерийн асуудлыг судлан хэрэгжүүлэх
- Аймгийн бодлого шийдвэрт санал өгч, төсөв мөнгө бүрдүүлэх
- Цаашид аймгийн бодлого шийдвэртэй уялдуулж хамтран ажиллахад зүгээр.
- Татвар өр барагдуулах ажил дээр эр хүн байх, татвар төлөгчидтэй бол эмэгтэйчүүд ажиллахад зүгээр байдаг. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн хэрэгцээ байгаа. Эмэгтэйчүүд хүнтэй зөв боловсон харьцдаг. Энэ талаар нилээд хөндөж ярих хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Цаг тухай бүр хэн хэрэгтэй байгааг тодорхойлоход л энэ асуудал чухал юм.
- Ажлын онцлогоос болж ихэвчлэн эр хүн авах шаардлага байдаг. Аймаг орон нутгийн жендэр хариуцсан мэргэжилтэн, алба хэлтэс нь мэдээлэл өгдөг бидэнтэй хамтран ажиллах шаардлагатай байна.
- Нэгд ажил хийхэд зардал шийдвэрлэх хэрэгтэй. Ажил хийх гэхээр төсөв байдаггүй.
- Хэрэгцээтэй бүхий л хэлбэрээр хамтран ажиллах хэрэгцээ шаардлага байна.

Жендерийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсвийг орон нутгийн байгууллагын түвшинд хэрэгжүүлэх зорилтын хүрээнд



- Төрийн байгууллагуудын зүгээс иргэд, олон нийт рүү чиглэсэн бүхий л үйл ажиллагаа, арга хэмжээнд оролцогчдыг хүйс, насны бүлгээр нь бүртгэлжүүлж, дүн шинжилгээ хийж ажиллах;
- Олон хүүхэдтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, бага орлоготой өрх толгойлсон эцэг (эх)-ийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн жендерийн мэдрэмжтэй бодлогыг дэмжих;



- Ажил, хөдөлмөр эрхэлдэггүй, хорт зуршлаас хамааралтай эрэгтэйчүүдийн нийгэм дэх оролцоог нэмэгдүүлэх, ажил хөдөлмөр эрхлүүлэх бодлого гарган ажиллах;
- Орон нутгийн хэмжээнд жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар хорооноос сум, багтай хамтран ажиллах удирдамж гарган хэрэгжүүлэх;



- Сумын Засаг дарга, хэлтэс, агентлагийн дарга нарын үр дүнгийн гэрээнд Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тусган хэрэгжүүлэх;
- Эрэгтэйчүүдийн дундаж наслалтын шалтгааныг тодруулж, тэдний дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн хөтөлбөр, бодлого гарган хэрэгжүүлэх;

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавхийг бэхжүүлэх зорилтын хүрээнд



- Жендэрийн салбар хорооны үйл ажиллагааг тогтмолжуулж, салбар хорооны мэдээллийг олон нийтэд хүргэж байх ажлыг эрчимжүүлэх;
- Төрийн албан хаагчдын жендэрийн талаарх ойлголт, хандлагыг сайжруулах, манлайллыг бий боолгох чиглэлээр чадавхжуулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх;
- Аймаг, сумын ЗДТГ-ын гэр бүл, хүүхэд залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах, жендерийн асуудлаар мэргэшүүлэх;
- Жендэрийн талаархи ойлголт, мэдээллийг багтаасан гарын авлага бэлтгэн иргэдэд тараах;
- Жендэрийн чиглэлээр сургалт хийх, зөвлөгөө өгөх орон нутгийн зөвлөхүүдийг бэлтгэн хамтран ажиллахад анхаарах;

Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд



- Аймаг, сумын ИТХ-д иргэдийг төлөөлөх эмэгтэй төлөөлөгчийн тоог нэмэгдүүлэх, квот тогтоож өгөх
- Эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд ажиллахад бэлтгэж, чадавхжуулах
- Нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх



Ашигласан материал.

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай” Монгол улсын хууль
Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр
Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөр боловсруулах удирдамж
2017 оны статистикийн мэдээлэл
Аймгийн хэмжээнд мөрдөгдөж байгаа дэд хөтөлбөрүүд (23)

АНХААРАЛТАВЬСАНД БАЯРЛАЛАА

....



Дундговь аймгийн ЗДТГ, Нийгмийн бодлогын
хэлтсийн мэргэжилтэн Р.Лхагвадорж



99019320



Lhagwaa0617@yahoo.com